



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Загвар тусламж, үйлчилгээ үзүүлэх
өрхийн эрүүл мэндийн төвийг ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8.1.2, 8.1.4 дэх заалтуудыг үндэслэн Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тусламжийн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан Тусламжийн хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3 төслийн хүрээнд, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны “Энэрэнгүй сэтгэл”, Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны “Одонт манал” Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг лабораторийн загвар тусламж, үйлчилгээ үзүүлэх Өрхийн эрүүл мэндийн төв болгон ажиллуулсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвд лабораторийн оношилгоо, шинжилгээний загвар тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, төвүүдэд хуваарилсан 128,366,000.00 (нэг зуун хорин найман сая, гурван зуун жаран зургаан мянган) төгрөгийн үнэ бүхий лабораторийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглах, урвалж оношлуур, дагалдах хэрэгслийн зарцуулалтад хяналт тавих, шинжилгээ хийх өрөө тасалгааны нөхцөлийг бүрдүүлэх, сорьцтой ажиллах биологийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдөн ажиллаж, иргэдэд тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагааны явцын тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт тогтмол мэдээлж ажиллахыг “Энэрэнгүй сэтгэл”, “Одонт манал” Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /С.Туул/-т тус тус үүрэг болгосугай.

4. Төсөл хэрэгжих явцад шаардлагатай багаж хэрэгслээр хангах, хүний нөөцийг сургах, дадлагажуулах ажлыг хариуцан, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Азийн хөгжлийн банкны ЭМСХХ-3 төслийн удирдагч /Б.Булганчимэг/-д даалгасугай.

5. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулан сайдын зөвлөлийн хуралд 2014 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

002873

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга А.Эрдэнэтуяад даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

Хүснэгт
Төрөл
Хүснэгт

168
Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 21 өдрийн 438 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Өрхийн эрүүл мэндийн төвд лабораторийн оношилгоо, шинжилгээний загвар тусламж, үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратеги” ЭМС-ын 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 239 дүгээр тушаалд “Бүх нийтэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг хүн амын өсөн нэмэгдэж байгаа эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, иргэд, үйлчлүүлэгчдийн хүсэн хүлээлтэнд нийцэхүйц чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээг үзүүлнэ” хэмээн стратегийн зорилгоо тодорхойлсон билээ.

1.2 Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан Тусламжийн хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3 төслийн хүрээнд, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны “Энэрэнгүй сэтгэл”, Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны “Одонт манал” Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд лабораторийн оношилгоо, шинжилгээний загвар тусламж, үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.3 “Энэрэнгүй сэтгэл”, “Одонт манал” Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь Эрүүл мэндийн сайдын 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 248 дугаар тушаал “Өрхийн эрүүл мэнд төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц”-д заасан тусламж, үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ лабораторийн оношилгоо, шинжилгээний загвар тусламж, үйлчилгээг энэхүү журмыг баримтлан үзүүлнэ.

Хоёр. Өрхийн эрүүл мэндийн төвийн эрх, үүрэг

2.1 Тоног төхөөрөмжийг хөрөнгийн бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглах, урвалж оношлуур, дагалдах хэрэгслийн зарцуулалтад хяналт тавих

2.2 Шинжилгээ хийх өрөө тасалгааны нөхцөлийг бүрдүүлэх, сорьцтой ажиллах биологийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдөн ажиллах

2.3 Иргэдэд энэхүү журамд заасан жагсаалтын дагуу тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх

2.4 Шинжилгээ хийх хүний нөөцийг бүрдүүлж, эмч, лаборантыг орон тооны ажилтнаар тогтмол ажиллуулах

2.6 Лабораторын хог хаягдлыг ЭМС-ын 2011 оны 158 дугаар тушаалд заасны дагуу устгаж, зайлуулах

- 2.7 Тусламж, үйлчилгээний талаарх явцын тайланг Нийслэлийн эрүүл мэндийн газарт, тогтмол мэдээлж, ажиллах
- 2.8 Лабораторийн тусламж, үйлчилгээний талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангуулах
- 2.9 Иргэдэд загвар тусламж, үйлчилгээний талаар сурталчилгаа хийж, үнэ төлбөргүй үйлчлэх
- 2.10 Загвар тусламж, үйлчилгээний талаарх гүйцэтгэлийн тайлан болон төсөл дууссаны дараа цаашид хэрхэн үргэлжлүүлэх талаарх санал, дүгнэлтийг ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, НЭМГ-т хүргүүлэх

Гурав. Нийслэлийн эрүүл мэндийн газрын эрх, үүрэг

- 3.1 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр удирдах
- 3.2 Шинжилгээний хариуг хянаж баталгаажуулах, эргэлзээтэй тохиолдлыг шийдвэрлэх асуудлыг Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл болон салбар амбулаторын лабораторын кабинетад шилжүүлэн шийдвэрлүүлэх
- 3.3 Төслийн хугацаанд гематологи, биохимийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээнд хамруулж, үнэлгээ хийх
- 3.4 Төвүүдийн үйл ажиллагааны явцын тайланд дүгнэлт хийж, санал зөвлөмж боловсруулах

Дөрөв. Азийн хөгжлийн банкны ЭМСХХ-3 төсөл хэрэгжүүлэх нэгжийн эрх, үүрэг

- 4.1 Төвүүдэд үзүүлэх лабораторийн оношилгоо, шинжилгээг гардан хийх эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх, сургах, дадлагжуулах ажлыг зохион байгуулах
- 4.2 Тоног төхөөрөмжийг хугацаанд нь нийлүүлж, суурьлуулах
- 4.3 Урвалж оношлуур, дагалдах хэрэгслээр төслийн хугацаанд хангах
- 4.4 Хөндлөнгийн судалгааны байгууллагаар загвар тусламж, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг гүйцэтгүүлж, санал дүгнэлт боловсруулах

Тав. Лабораторийн оношилгоо, шинжилгээний жагсаалт

- 5.1 Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багцад заасан дараах шинжилгээнүүдийг хийх.
- 5.2 Хагас автомат анализатороор хийгдэх шинжилгээ
 - Шээсний ерөнхий шинжилгээ
 - Биохимийн шинжилгээ /ALAT, ACAT, альбумин, уураг, креатинин, цагаан эс,



- глюкоз, холестрин, шүлтлэг фосфатаз, амилаз/
- Цусны ерөнхий шинжилгээ
- 5.3 Түргэвчилсэн оношилгуураар хийгдэх шинжилгээ
 - Жирэмсэн тодорхойлох өндөр мэдрэг сорил
 - Цусны серологи /тэмбүү/
 - Иммунологийн шинжилгээ /гепатит С, гепатит В, ХДХВ, Н.пилори/
- 5.4 Микроскопийн тусламжтай хийгдэх шинжилгээ
 - Эмэгтэйчүүдийн сорил /PAP/
 - Үтрээ ба шээсний сүвний сорьц шинжлэх
 - Өтгөний шинжилгээ /далд цус/

Зургаа. Хяналт үнэлгээ

- 6.1 Загвар тусламж, үйлчилгээний явцын үнэлгээг ЭМЯ-ны ЭТХ, НЭМГ, Дүүргүүдийн ЭМН, Азийн хөгжлийн банкны "ЭМСХХ-3" төслийн хүрээнд гүйцэтгэх
- 6.2 Төгсгөлийн хяналт, үнэлгээг ЭМЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар гүйцэтгэх
- 6.3 Хяналт үнэлгээний дүнг Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэр гаргуулах

ЗМСХХ-3 төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны “Энэрэнгүй сэтгэл”, Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны “Одонт манал” Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хуваарилах лабораторийн тоног төхөөрөмж, урвалж оношлуур, дагалдах хэрэгслийн жагсаалт

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 сарын 21 өдрийн 1938 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

Тоног төхөөрөмжийн нэрс	Гарал үүсэл	Марк загвар	Чингэлтэй дүүргийн 15-р хорооны “Энэрэнгүй сэтгэл” ӨЭМТ	Сонгинохайрхан дүүргийн 22-р хорооны “Одонт манал” ӨЭМТ	Хэмжих нэгж	Нийт тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1 Ширээний центрифуг	Герман, Human Gesellschaft fur Biochemica und Diagnostica mbH	HumMax 4	1	1	ш	2	3,893,000.00	7,786,000.00
2 Лабораторийн хөрөгч	Хятад, Naier Medical	НУС-68A	1	1	ш	2	1,264,000.00	2,528,000.00
3 Био аюулгүйн хайрцаг	Солонгос, Daehan Labtech Co., Ltd	LSB-0101V	1	1	ш	2	7,318,000.00	14,636,000.00
4 Халдвартай, хури үзүүртэй хог хаягдлыг хийх сав	Хятад, All Pro Corporation	Waste bin	10	10	ш	20	68,000.00	1,360,000.00

5	Химийн урвалж оношлуур хадгалах лабораторийн шүүгээ	Хятад, All Pro Corporation	Medical storage cabinet	1	1	ш	2	525,000.00	1,050,000.00
	Хагас автомат клиник химийн анализатор. Чанарын хяналтын уусмал, урвалжийн хамт	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH	Numalyzer 3500	1	1	Иж бүрдэл	2	18,567,000.00	37,134,000.00
6	Өөх тосны солилцоог үзэх урвалжууд	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH		1	1	Иж бүрдэл	2	707,000.00	1,414,000.00
	Элэгний үйл ажиллагааг үзэх урвалжууд	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH		1	1	Иж бүрдэл	2	271,000.00	542,000.00
	Бөөрний үйл ажиллагааг үзэх урвалжууд	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH		1	1	Иж бүрдэл	2	27,000.00	54,000.00
7	Пипетик, Пипетикний хошуу, Пипетикний тавиурын хамт	India, Fine Care Biosystems Inc,	Accumax Variabel volume Micropipette	1	1	Иж бүрдэл	2	278,000.00	556,000.00
	Цус авах иж бүрдэл Вакуумтэйгнэрийн зүү	Хятад, Allpro Corporation	Disposable vacuum blood collection tube	1200	1200	ш	2400	40.00	96,000.00
	Вакуумтэйгнэрийн хуруу шил, citrate 3,28%			400	400	ш	800	200.00	160,000.00

8	Вакумтейнэрийн хуруу шил, EDTA (K3)	Хятад, Allpro Corporation		400	400	ш	800	200.00	160,000.00
	Вакумтейнэрийн хуруу шил, Нэмэлтгүй			400	400	ш	800	200.00	160,000.00
	Вакумтейнэрийн хуруу шилний тавиур			2	2	ш	4	39,000.00	156,000.00
	Микроскоп шинжилгээний иж бүрдэл 2 Нүдний микроскоп		Humascope Classic Led	1	1	ш	2	2,761,000.00	5,522,000.00
9	Микроскопийн шинжилгээний тавиур шил бүрхүүл шилний хамт хайрагдандаа 100 ширхэгээр савлагдсан	Герман, Human Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH		30	30	ш	60	32,000.00	1,920,000.00
	Граммын будаг 125мл			30	30	ш	60	99,000.00	5,940,000.00
	Eosin Nematohulin stain (литр)			5	5	ш	10	206,000.00	2,060,000.00
	Хуруу шил			400	400	ш	800	560.00	448,000.00
	Горьевын тор буюу эс тоолох тор			1	1	ш	2	127,000.00	254,000.00
	Гемоглобин метр иж бүрдэл		Humameter Nb plus	1	1	ш	2	1,800,000.00	3,600,000.00
	Нв урвалж			500	500	ш	1000	6,000.00	6,000,000.00
10	Нв-ийн хяналтын шингэн	Diagnostica mbH		1	1	Иж бүрдэл	2	24,000.00	48,000.00

11	Пусны улан эсийн тунх хурдыг тодорхойлох (ESR) багаж	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH	NumaSed 25 Mix	1	1	ш	2	4,540,000.00	9,080,000.00
	(ESR) хуруу шил, пластик, 1.2мл (ESR) хуруу шилний тавиур	Хятад, All pro Corporation Co.,Ltd		2000	2000	ш	4000	230.00	920,000.00
12	Жирэмсний гормон буюу хорин гонадотропин тодорхойлох өндөр мэдрэг оношлуур	Солонгос, Standard Diagnostics Inc	SD hCG, hCG (U/S)	200	200	ш	400	440.00	176,000.00
	Билирубинийг тодорхойлогч	Хятад, Ningbo David Medical Device Co.,Ltd	JH20-1C	1	1	ш	2	5,035,000.00	10,070,000.00
14	Хатас автомат шээсний анализатор	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH	Combylizer 13	1	1	ш	2	2,399,000.00	4,798,000.00
	Шээсний шинжилгээний туузан индикатор, 100 ширхэгээр савлагдсан	Герман, Нуман Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH		10	11	хайр-цаг	21	45,000.00	945,000.00
15	Уушигны багтаамж хэмжигч аманд зуух хошууны хамт	Итал, GIMA S.P.A.	PIKO 1	1	1	ш	2	125,000.00	250,000.00
	Уушигны багтаамж хэмжигчийн аманд зуух хошуу			150	150	ш	300	2,100.00	630,000.00
	Сахар хэмжигч, ялтасын хамт			1	1	ш	2	38,400.00	76,800.00
	Ялтас (Rapid test strips)			300	300	ш	600	680.00	408,000.00

16	Өндөг цоологч үзэг Өндөг цоологч зуу	Солонгос, Standard Diagnostics Inc	Codefee	1	1	ш	2	3,600.00	7,200.00
	Найрлагандаа сахар агуулсан хяналтын шингэн			300	300	ш	600	80.00	48,000.00
17	Глюкозосон гемоглобин тодорхойлох оношлуурын иж бүрдэл	Солонгос, Incofia Co., Ltd	Clover A 1 c	1 (300 шинж- нд)	1 (300 шинж- нд)	ш	1 (600 шинж- нд)	29,000.00	29,000.00
	Ялгаа (Rapid test strips)			1	1	ш	2	1,142,000.00	2,284,000.00
	Буферийн уусмал (buffer rinses)			150	150	ш	300	6,900.00	2,070,000.00
	Өндөг цоологч			1 (150 шинж- нд)	1 (150 шинж- лгээнд)	ш	2 (150 шинж- нд)	68,500.00	137,000.00
18	Шинжлэгч цусыг шингээгч (Blood applicator)	Солонгос, Standard Diagnostics Inc		1	1	ш	2	32,000.00	64,000.00
	Клиник иммунологийн түргэвчилсэн оношлуурын С-Реактивт уургийг тодорхойлох түргэвчилсэн латекс оношлуурын иж бүрдэл Rapid CRP test kit (Latex tests)			150	150	ш	300	370.00	111,000.00
		Герман, Нипан Gesellschaft für Biochemica und Diagnostica mbH,		Нипатех CRP	Иж бүрдэл	2	100,000.00	200,000.00	
				1	1	ш	2	100,000.00	200,000.00

Антистрептолизин-О тодорхойлох түргэвчилсэн латекс оношлуурын иж бүрдэл Rapid ASLO test kit (Latex tests)							
	Numatex ASO	1	1	Иж бүрдэл	2	100,000.00	
		60	60	ш	120	3,000.00	
Халдварт өвчний түргэвчилсэн оношлуурууд Хламид илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл Sflamudia rapid test kit		60	60	ш	120	6,000.00	720,000.00
Заг хүйтэн илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл Solonhos genital swab rapid kit		60	60	ш	120	1,000.00	120,000.00
В гепатит илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл Hepatitis B rapid test kit		40	40	ш	80	2,000.00	160,000.00
С гепатит илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл Hepatitis HCV rapid test kit							

Солонгос, Standard
Diagnostics Inc

ДОХ илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл HIV quick rapid test kit		40	40	ш	80	2,000.00	160,000.00
Хеликобактер илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл H. Pylori rapid test kit	Солонгос, Standard Diagnostics Inc	60	60	ш	120	2,000.00	240,000.00
Тэмбүү илрүүлэх түргэвчилсэн оношлуурын иж бүрдэл SYRNLIS RPR test, reduced accessory rapid kit		20	20	ш	40	2,000.00	80,000.00
Хавдрын түргэвчилсэн оношлуурууд		Standard Diagnostic Inc, Солонгос	90	90	ш	180	2,000.00
Нийт дүн:		128,366,000.00					

